



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/358

Есөнбулаг сум

Захирамж хэсэгчлэн хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйл, 49.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4 дэх хэсэг, аймгийн Онцгой комиссын 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн "Хурдан морины уралдаан зохион байгуулах тухай" 159 дүгээр захирамжийн 1 дэх заалт "Аймгийн зуны урд, хойд бүсийн 9 насны хурдан морьдын уралдааныг 07 дугаар сарын 18-22 ны өдрүүдэд Дарив, Эрдэнэ сумуудад, аймгийн зуны төвийн бүсийн 9 насны хурдан морьдын уралдааныг 07 дугаар сарын 31-ээс 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд Шарга сумд тус тус зохион байгуулах" гэснийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Дарив, Эрдэнэ, Шарга сумын Засаг дарга нар, Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), Онцгой байдлын газар (Ц.Лувсанжамц), Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



